



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20~~23~~²⁴ оны 08 сарын 30 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Санхүүгийн
тайланг батлах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн “Си Эс Ай аудит” ХХК-иар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 8.

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 46-р зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Гермес центр" ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашиг 1,053,105,038.90 төгрөгийн
 - 981,787,512.5 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
 - 30,000,000.0 төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд
 - 41,317,526.4 төгрөгийг хуримтлагдсан ашигт тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76.1.12-р заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 12 төгрөг 50 мөнгө (арван хоёр төгрөг тавин мөн)-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 09-р сарын 18-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2024 оны 09-р сарын 23-ны өдрөөс эхэлж хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн харилцах дансанд болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-тай гэрээ байгуулан 2024 оны 11-р сарын 15-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга,
гишүүдийг шинэчлэн томилох тухай

“Компанийн тухай хууль”-ийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.21 дэх заалт, “Компанийн засаглалын кодексийн зарчим” болон компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес Центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга гишүүдийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны нэрийг компанийн “Эрсдэл аудитын хороо” болгон өөрчилсүгэй.
3. Шинэчлэн томилогдсон хороодын дарга, гишүүдэд “Компанийн тухай хууль”, “Компанийн дүрэм”, “ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам”, “Компанийн эрсдэлийн удирдлагын заавар”-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Журам
батлах бухай

“Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 145 тоот шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодексийн зарчим”-д нийцүүлэн “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан 2022 оны 8-р сарын 26-ны өдрийн 10-р тогтоолоор баталсан “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хүчингүйд тооцсугай.
3. Шинээр батлагдсан журмыг оролцогч талуудад нээлттэй байдлаар түгээх, мөн Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ажлын төлөвлөгөө болон сургалтын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76-р дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Компанийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес Центр” ХК-ийн ТУЗ-ийн 4-р улирлын “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралт №1-р, ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын төлөвлөгөөг хавсралт №2-р тус тус баталсугай.
2. ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохистой явуулах, хэрэгжилтэд хяналт тавих, жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг ТУЗ-д танилцуулах, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Журам
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 145 тоот шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодексийн зарчим”-д нийцүүлэн “Компанийн ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын үйл ажиллагааг дүгнэх журам”-ыг хавсралтын дагуу баталсугай.
2. Шинээр батлагдсан журмыг оролцогч талуудад нээлттэй байдлаар түгээх, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²⁴ оны ⁰⁸ сарын ³⁰ өдөр

Дугаар ¹⁴

Улаанбаатар хот

Журам
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 145 тоот шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодексийн зарчим”-д нийцүүлэн “Компанийн ажилтан ажиллагсдын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг хавсралтын дагуу баталсугай.
2. Шинээр батлагдсан журмыг оролцогч талуудад нээлттэй байдлаар түгээх, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20...⁰⁴ оны ⁰⁸ сарын ³⁰ өдөр

Дугаар ¹⁵...

Улаанбаатар хот

Журам
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.32.11 дэх заалт болон тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Хөдөлмөрийн тухай хууль”-нд нийцүүлэн “Гермес Центр” ХК-ийн ажилтан ажиллагсдын ажлын байранд мөрдөж ажиллах хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан 2014 онд баталсан “Гермес Центр” ХК-ийн ажилтан ажиллагсдын ажлын байранд мөрдөж ажиллах хөдөлмөрийн дотоод журмыг хүчингүйд тооцсугай.
3. Шинээр батлагдсан журмыг оролцогч талуудад нээлттэй байдлаар түгээх, мөн Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), компанийн ажилтан ажиллагсдад тус тус үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН